

1. Уралдаанд багаар оролцох бөгөөд баг нь тухайн сургуулийн 10-12 дугаар ангийн 3-аас 5 хүртэлх тооны сурагч болон 1 багшаас (тухайн сургуулийн Математикийн багш байна) бүрдэнэ. Нэг сургуулиас оролцох багийн тоонд хязгаар заахгүй. Баг бүр өөрийн оноосон нэртэй байна. Тэмцээнд оролцож байгаа багийн гишүүд (сурагчид болон зөвлөх багш нар) зөвхөн нэг багт харьяалагдана. Математик, статистик загварчлалын уралдааныг зохион явуулах журам, удирдамжийг тухайн сургуулийн төлөөлөгч багш/захиргаа нь сурагчид, багш нарт танилцуулна. Төлөөлөгч багш дараах үүрэгтэй:

- Уралдааны журам, удирдамжийг сургуулийн багш, сурагчдад танилцуулж зарлана.
- Бүртгэлийн маягтыг www.mat.mn болон www.facebook.com/math.setguul хуудаснаас авч бөглөн 2018 оны 3-р сарын 16-наас өмнө math.setguul@gmail.com хаягаар ирүүлнэ.
- Сургуулийн захиргаанд ажлын явцыг тогтмол танилцуулж байна.
- Уралдааны явцад болох сургалт, танилцуулгын талаар оролцох багуудыг мэдээллээр хангана.

2. Уралдааны бүртгэл 2018 оны 3-р сарын 5-ны өдөр эхлэх бөгөөд оролцох багууд 2018 оны 3-р сарын 16-ны дотор хүсэлтээ ирүүлнэ. 3. Багууд бүртгэл хаагдсанаас хойш материалаа ирүүлэх хүртэлх хугацаанд уралдааны талаар болон статистик мэдээлэл цуглуулах, боловсруулах, математик загвар боловсруулах мөн бичгийн ажлын боловсруулалт, стандартын талаар 2 удаагийн сургалтад хамрагдах бөгөөд сургалтыг онлайн байдлаар тусгай хөтөлбөрийн дагуу ҮСХ ба ММБА-аас удирдан явуулна.

3. Эхний шатны шалгаруулалтад тэнцсэн 10 баг танилцуулга бэлтгэн шүүгчдийн комисст нэгдсэн байдлаар илтгэл хийж бүтээлээ хамгаална. Бусдын бүтээлээс хуулбарласан, багийн гишүүдээс бусад гуравдагч этгээдийн туслалцаа авсан нь илрэх буюу нотлогдвол тухайн бүтээлийг хүчингүйд тооцох болон багийг уралдаанаас хасах хүртэл арга хэмжээ авна.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Сэдэвтэй холбоотой статистик өгөгдөл цуглуулан, математик загвар боловсруулж уралдаанд дэвшүүлсэн асуудлын талаарх өөрсдийн ойлголт, дүгнэлт мөн асуудлыг хэрхэн шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулсан байдлаа тусгаж үр дүн, шийдлээ танилцуулсан байна. Математик загвараа ашиглаж хийсэн тооцооллын хэсгээ үр дүнгийн хамт багтаасан байна.
- Бүтээлээ Times New Roman, Arial гэх мэт стандарт үсгийн фонт ашиглан бичсэн байна. Цаасны хэмжээ А4, үсгийн өндөр 12, мөр хоорондын зай 1, цаасны захуудаас авах хэмжээ нь зүүн талаас 2.2 см, дээд, доод,

баруун талаас тус бүр 2 см байна. Нийт хуудасны тоо 20-иос хэтрэхгүй байна.

- Бүтээлийг шүүхдээ өөрийн санаа, бүтээлч байдал, үр дүн, амьдралд хэрэгжихүйц байдал, өвөрмөц санаа, бичлэгийн стандартыг хангасан байдал, танилцуулга,
- тайлбар хамгаалалт зэргийг харгалзан үнэлнэ.

4. Комиссын шийдвэрээр түрүүлсэн болон шагналт байрт орсон багуудын талаар өдөр тутмын хэвлэл, цахим хуудас, телевизийн сүвгуудаар олон нийтэд мэдээлэн танилцуулж шагналыг гардуулна.